ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.22 № 01/34 ДУА-2017/113/СТА-ТШ3

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ОЮУНТӨГС ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад байгууллагын төсвөөс хувь хүнд 56,000.00 төгрөгийн албан томилолтын зардал олгож төсвийг хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-д */Төрийн албан хаагчид дараах нөхөн төлбөр олгоно./*, 29.2.1-д */Албан томилолтын зардал/*, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах /* Засгийн газрын 1995 оны 218 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1.5-д */ Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор нийтийн тээврийн тогтмол үйлчилгээгүйн улмаас өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу тодорхой хугацаагаар зохих шийдвэр гарган явуулж ажиллуулсан нөхцөлд албан томилолтын зардал олгоно./*, Сангийн Сангийн сайдын 1992 оны 30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1-д */Ажилчин албан хаагчдыг тогтмол ажилладаг газраас нь өөр газарт албан үүрэг гүйцэтгүүлэхээр улсын үйлдвэрийн газар, төсөвт байгууллагын удирдлагын шийдвэрээр тодорхой хугацаагаар явуулж ажиллуулахыг албан томилолт гэнэ /* заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т */Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т */Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д */Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг*

С000000070

*таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал /* заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Албан томилолтын зардлыг олгохдоо холбогдох хууль тогтоомж, журмын дагуу олгож, төсвийг зариулалтын дагуу үр ашигтай зарцуулах.
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Сургуулийн захирал Б.Оюунтөгс, нягтлан бодогч Б.Цэндмаа нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН[1]:** **ЗӨВШӨӨРСӨН:**

АХЛАХ ШИНЖЭЭЧ Д.ИХБАЯР ЗАХИРАЛ Б.ОЮУНТӨГС

НЯГТЛАН БОДОГЧ Б.ЦЭНДМАА

---

[1] *Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*